**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

# Нийслэлийн Баянгол дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2025/017/НА-СТА-3ГТС

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга Ч.Болд<br>Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn<br><br>Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга Х.Түвшинбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: С.Гантөгс<br>Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn<br><br>Аудитор: Ж.Мөнхтуяа<br>Утас: 325093 Цахим хаяг: Munkhtuyaja@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.02.24 № 01/97

танай ______________ -ны № ______________ -т

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА Г.БАТБАЯР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Баянгол дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 85,160.5 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд 3,070,965.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн 627,268.8 мянган төгрөгийн авлага шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шилжиж, авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр 2024 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй нийт 1,080,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн гэрээ, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд нийт 73,840.0 мянган төгрөгийн гэрээг 17 аж ахуйн нэгжтэй байгуулж ажилласан байна.

02023471

C:\Users\zendmene.d\Desktop\2025\Word\Yvsan bichig\2025.02.24 BGD HEDS.docx

**Бусад асуудлын хэсэг**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөтөлбөрт тусгасан болон тус сангаар дамжин хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэл, зарцуулалт, хүрсэн үр дүн зэрэг асуудлуудыг аудитын цаг хугацаа, хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитад бүрэн хамруулаагүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* */төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,268,157,919.80** | **3,098,555,770.00** |
| **33** | **АВЛАГА** | 3,268,157,919.80 | 3,098,555,770.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 329,409,032.80 | - |
| **335** | **Бусад авлага** | 5,713,939.00 | 32,380,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 923,939.00 | 27,590,000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 4,790,000.00 | 4,790,000.00 |
| **336** | **Зээлийн авлага** | 2,933,034,948.00 | 3,066,175,770.00 |
| **3361** | **Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага** | 2,933,034,948.00 | 3,066,175,770.00 |
| 33612 | Хувь хүмүүст олгосон зээл | 2,933,034,948.00 | 3,066,175,770.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,268,157,919.80** | **3,098,555,770.00** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **500,000.00** | **1,515,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 500,000.00 | 1,515,000.00 |
| **413** | **Өглөг** | 500,000.00 | 1,515,000.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 500,000.00 | 1,515,000.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 500,000.00 | 1,515,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,267,022,919.80** | **3,097,040,770.00** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,267,022,919.80 | 3,097,040,770.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 3,267,022,919.80 | 3,097,040,770.00 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,395,431,474.00 | 3,267,022,919.80 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 871,591,445.80 | (169,982,149.80) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,267,522,919.80** | **3,098,555,770.00** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 2,367,095,939.00 | 2,139,334,759.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,362,595,939.00** | **2,139,334,759.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,362,595,939.00 | 2,139,334,759.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 2,362,172,000.00 | 2,139,173,800.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,173,172,000.00 | 2,003,653,800.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 189,000,000.00 | 135,520,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 120009 | Бусад орлого | 423,939.00 | 160,959.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,500,000.00** | **-** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,500,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,500,000.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,495,504,493.20** | **2,309,316,908.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,495,504,493.20** | **2,309,316,908.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 84,806,153.20 | 38,934,976.88 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 84,806,153.20 | 38,934,976.88 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 84,806,153.20 | 38,934,976.88 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,410,698,340.00 | 2,270,381,931.12 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 521,524,209.00 | 402,319,262.81 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 521,524,209.00 | 402,319,262.81 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 810,678,572.31 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 480,345,601.31 |
| 213304 | Хөрөнгийн | - | 330,332,971.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 167,550,000.00 | 136,060,959.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 167,550,000.00 | 136,060,959.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 721,624,131.00 | 921,323,137.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 721,624,131.00 | 921,323,137.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **871,591,445.80** | **(169,982,149.00)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **28,949,856.73** | **164,300,220.05** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,367,595,939.00** | **2,470,047,730.80** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,363,095,939.00** | **2,470,047,730.80** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,363,095,939.00 | 2,470,047,730.80 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 2,362,172,000.00 | 2,469,506,771.80 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,173,172,000.00 | 2,003,653,800.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 189,000,000.00 | 135,520,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | - | 330,332,971.80 |

| | | | |
|---|---|---|---|
| 120009 | Бусад орлого | 923,939.00 | 540,959.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,500,000.00** | **-** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,500,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,500,000.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **3,111,837,465.00** | **3,416,906,908.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,111,837,465.00** | **3,416,906,908.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **84,806,153.20** | **38,934,976.88** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 84,806,153.20 | 38,934,976.88 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 84,806,153.20 | 38,934,976.88 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,027,031,311.80** | **3,377,971,931.12** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,807,524,209.00 | 1,509,909,262.81 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,807,524,209.00 | 1,509,909,262.81 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 329,409,032.80 | 480,345,601.31 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 329,409,032.80 | 480,345,601.31 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 168,473,939.00 | 466,393,930.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 168,473,939.00 | 466,393,930.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 721,624,131.00 | 921,323,137.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 721,624,131.00 | 921,323,137.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(744,241,526.00)** | **(946,859,177.20)** |
| 14 | **Бусад эх үүсвэр** | 744,241,526.00 | 946,859,178.00 |
| 145004 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх | 744,241,526.00 | 946,859,178.00 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **744,241,526.00** | **946,859,178.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | | |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 744,241,526.00 | 946,859,178.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* **/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|
| C01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 3,267,022,919.80 | 3,267,022,919.80 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 3,267,022,919.80 | 3,267,022,919.80 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 3,267,022,919.80 | 3,267,022,919.80 |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 3,267,022,919.80 | 3,267,022,919.80 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 3,267,022,919.80 | 3,267,022,919.80 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | -169,982,149.80 | -169,982,149.80 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,097,040,770.00** | 3,097,040,770.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* **/төгрөгөөр/**

| Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,003,653,800.00 | 1,548,844,239.69 | 454,809,560.31 | 77.3 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 2,003,653,800.00 | 1,548,844,239.69 | 454,809,560.31 | 77.3 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 66,250,000.00 | 38,934,976.88 | 27,315,023.12 | 58.8 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 66,250,000.00 | 38,934,976.88 | 27,315,023.12 | 77.3 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 66,250,000.00 | 38,934,976.88 | 27,315,023.12 | 58.8 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,937,403,800.00 | 1,509,909,262.81 | 427,494,537.19 | 77.9 |
| Бусад урсгал шилжүүлэг | 1,937,403,800.00 | 1,509,909,262.81 | 427,494,537.19 | 77.9 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,937,403,800.00 | 1,509,909,262.81 | 427,494,537.19 | 77.9 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,003,653,800.00 | 1,548,844,239.69 | 454,809,560.31 | 77.3 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,003,653,800.00 | 1,548,844,239.69 | 454,809,560.31 | 77.3 |
| ЗГ-н тусгай сангаас санхүүжих | 2,003,653,800.00 | 1,548,844,239.69 | 454,809,560.31 | 77.3 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 508,976.6 мянган төгрөгийн 2 алдаа [1] илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

Аудитаар нийт 86,160.5 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 27,590.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 57,570.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 зөвлөмж хүргүүллээ.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | НББ-ийн үйл ажиллагаар буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| санхүүгийн байдлын тайланд татаас санхүүжилтийн авлагыг илүү тайлагнасан | 1 | 481,386.60 | | | 1 | 481,386.60 | 1 | 481,386.60 | | | | |
| Тайлант хугацаанд бүрэн хэрэгжээгүй ажлыг шууд зардлаар бүртгэсэн байна. | 1 | 27,590.00 | 1 | 27,590.00 | | | 1 | 27,590.00 | | | | |
| Дүн | 2 | 508,976.6 | 1 | 27,590.00 | 1 | 481,386.0 | 2 | 508,976.6 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Эргэн төлөгдөх нөхцөлтэй олгогдсон санхүүгийн дэмжлэгийн хэрэгжилтийн тайлан, холбогдох анхан шатны баримтаар баримтаар нотлогдохгүй байна. | 1 | 16,500.0 | | | | | 1 | 16,500.0 | | | | |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан болон ажлын байр дэмжих хөтөлбөрүүдээс тайлант онд иргэдэд олгосон санхүүгийн дэмжлэгээс гэрээний хавсралтад заасан хуваарийн дагуу төлөгдөөгүй байна. | 1 | 26,690.5 | | | | | 1 | 26,690.5 | | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадвар олгох сургалтад хамрагдсан иргэдэд сургалт зохион байгуулсан тал чадамжийн гэрчилгээг олгосон эсэх нь тодорхойгүй хуулбарыг санхүүгийн баримтанд хавсаргаагүй байна. | 1 | 11,000.0 | | | | | 1 | 11,000.0 | | | | |
| Тайлант онд үүссэн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. | 1 | 380.0 | | | | | 1 | 380.0 | | | | |
| Байгууллагын даргын 2024.06.07-ны өдрийн тушаалаар эмэгтэйчүүд, залуучууд, ахмадуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн судалгаа, нөлөөллийн ажилд нийт 55,180.0 мянган төгрөгийн зардал гаргахаар баталж МҮХАҮТ-тай гэрээ байгуулсан. Гэвч гүйцэтгэсэн ажлын тайлан болон холбогдох баримтууд шаардлага хангаагүйгээс тайлант онд авлага үүсгэсэн байна. | 1 | 27,180.0 | | | 1 | 27,180.0 | | | | | | |
| **Дүн** | **5** | **85,160.5** | | | 1 | 27,180.0 | **4** | **57,570.5** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ХЭДС-аас зохион байгуулсан сургалтууд Хөдөлмөр эрхлэлтийн үндсэний зөвлөлийн 01 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлсан ХЭДС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төсвийн хөтөлбөрийн 2024 оны зорилтот түвшин, хүрэх үр дүнд хүрээгүй байна. | 1 | 53,680.0 | | | | | 1 | 53,680.0 |
| **Дүн** | **1** | **53,680.0** | | | | | **1** | **53,680.0** |

## 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт гаргахаас татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | | + | | | | + | | |
| | **НИЙТ** | | | | | | | | |